

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

АУДИТЫН КОД:ХОА-2022/01/НА-СТА-ТЕЗ

Цахим хуудас: www.audit.mn

Ховд хот

2022 оны 4 сарын 20

Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Утас: 70433061

Цахим хаяг: Boldbaatarkhu@audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Цахим хаяг: tsetsesgsurena@audit.gov.mn

Утас: 70432545

Ахлах аудитор: Д.Мөнхтулга

Утас:70432545

Цахим хаяг: : Munkhtulga.d@audit.gov.mn

Аудитор: Д.Эрдэнэцэцэг

Утас:7043-2545

Цахим хаяг: Erdenetsestegd@audit.gov.mn

2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН БАЙДЛЫН ТАЙЛАН	5
2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН	5
2.3 АУДИТ ХИЙСЭН НЭГТГЭСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН.....	6
2.4 АУДИТ ХИЙСЭН НЭГТГЭСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН	8
2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН	8
2.6 АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН	10
3. АУДИТЫН ТАЙЛАН	11
3.1. Ерөнхий зүйл.....	11
3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	13
3.4 Материаллаг байдал	13
3.5.1 Мөнгөн хөрөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө.....	13
3.5.2 Авлага.....	15
3.5.3 Урьдчилгаа.....	16
3.5.4 Бараа материал	16
3.5.5 Үндсэн хөрөнгө.....	17
3.5.6 Өр төлбөр.....	18
3.5.7 Засгийн газрын хувь оролцоо	19
3.6. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	20
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	20
3.8 Аудитын гол асуудал	21
3.9. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	21
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	21
3.10. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар тодруулга.....	22
3.11 Харьяа байгууллагуудын аудитын дүнгийн талаар.....	23
3. Аудитын илрүүлэлт.....	25
4.1 Залруулсан алдаа	25
4.2 Төлбөрийн акт	25
4.3 Албан шаардлага:	25
4.5. Зөвлөмж.....	26
4. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ	28

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай
ЗДТГ	Засаг даргын дамгын газар
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
ОБГ	Онцгой байдлын газар
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
СХС	Сум хөгжүүлэх сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ААН	Аж ахуйн нэгж
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
БИТ 6	Бизнес инкубатор төв

АУДИТЫН ТАЙЛАНГ БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ:



ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2022 оны 04 сарын 20 өдөр

Дугаар 11

Ховд

Санхүүгийн аудитын тайланг баталгаажуулах тухай

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9 дэх заалт, Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх заалтууд, Монгол улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/207 "эрх үүрэг, шилжүүлэх тухай" тушаал, 2021 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 3.4.3 дахь заалт, 2021 оны А/87 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Ховд аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг нэгдүгээр хавсралтаар, 2021 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн аудитын тайланг хоёрдугаар хавсралтаар, аудитаар илэрсэн төлбөрийн актыг 3 дугаар хавсралтаар, зөрчил арилгуулах албан шаардлагыг 4 дүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2.Аудитын тайланг Үндэсний аудитын газрын хоёрдугаар газар, Ховд аймгийн Төсвийн Ерөнхийлөн захирагчид тус тус хүргүүлсүгэй.

3. Нэгдсэн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, үр дүнг 2022 оны 9 дүгээр сарын 10-ны дотор ирүүлэхийг аймгийн Засаг дарга /Б.Дүгэржав/-д зөвлөсүгэй.

4. Шийдвэрийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер, ахлах аудитор, аудитор нарт үүрэг болгосугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  БОЛДБААТАР



021010032



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА
Б.ДҮГЭРЖАВ ТАНАА

2022.04.20 № 2/196
танай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасны дагуу Ховд аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ховд аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  Х.БОЛДБААТАР



2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН БАЙДЛЫН ТАЙЛАН

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	27,897,027.40	33,807,026.30
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	10,742,235.50	14,783,113.50
33	АВЛАГА	8,825,818.00	9,920,678.80
34	УРЬДЧИЛГАА	2,118,486.70	1,743,772.70
35	БАРАА МАТЕРИАЛ	5,974,241.30	7,065,198.20
36	НӨӨЦИЙН БАРАА	236,245.90	294,263.10
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	195,596,657.70	220,960,339.60
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	195,596,657.70	220,960,339.60
39200	Биет хөрөнгө	181,157,136.50	206,420,257.70
39300	Биет бус хөрөнгө	14,353,723.50	14,454,284.10
39400	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	85,797.80	85,797.80
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	223,493,685.10	254,767,365.90
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	5,231,240.00	7,128,597.10
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	4,287,896.20	6,185,253.30
41300	Өглөг	747,562.00	2,215,376.50
41400	Урьдчилж орсон орлого	3,540,334.20	3,969,876.80
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	943,343.80	943,343.80
42200	Урт хугацаат зээл	943,343.80	943,343.80
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	218,262,445.00	247,638,768.80
51	Засгийн газрын хувь оролцоо	218,262,445.00	247,638,768.80
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	80,346,120.90	80,382,459.60
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	12,351,379.60	12,490,204.90
51102	Өмч /хувийн/ /ТӨҮГ/	5,010.00	5,010.00
51106	Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	3,000.00	1,174,288.90
51200	Хуримтлагдсан үр дүн	71,371,786.50	99,192,988.40
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	54,185,148.10	54,393,817.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	223,493,685.10	254,767,365.90

2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2020оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		246,506,250.50	149,430,673.70
11	ТАТВАРЫН ОРЛОГО		11,248,304.90	14,824,127.10
110	Орлогын албан татвар		9,300,403.40	10,903,708.50
1100	Хувь хүний орлогын албан татвар		9,889,455.00	11,502,511.10

1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		-589,051.60	-598,802.60
113	Хөрөнгийн албан татвар		1,136,862.00	1,699,316.20
118	Бусад татвар, төлбөр, хураамж		811,039.50	2,221,102.40
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	112,782,571.90	111,516,371.00
120	Нийтлэг татварын бус орлого		41,334,412.70	40,345,279.00
121	Хөрөнгийн орлого		128,808.40	3,678.10
122	Тусламжийн орлого		0	33,332.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг		71,319,350.70	71,134,081.90
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		122,475,373.70	23,090,175.60
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	202,228,888.50	107,450,711.40
21	УРСГАЛ ЗАРДАЛ		202,228,888.50	107,307,246.10
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		98,069,909.00	102,557,748.70
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		46,456,808.50	47,565,874.80
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		5,838,959.30	6,214,983.80
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		6,087,293.70	6,698,544.80
2104	Хангамж, бараа материалын зардал		14,998,526.80	16,366,337.20
2105	Нормативт зардал		3,831,094.00	3,043,001.90
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		336,960.90	291,713.20
2107	Томилолт, зочны зардал		138,228.40	151,246.70
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		2,445,343.60	2,158,350.60
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		17,936,693.90	20,067,695.80
212	ТАТААС		522,225.40	566,160.70
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		103,636,754.10	4,183,336.70
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		0	143,465.30
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		44,277,361.90	41,979,962.30
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		514.2	0
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		16,884,907.30	15,096,698.40
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		27,392,968.80	26,883,263.90

2.3 АУДИТ ХИЙСЭН НЭГТГЭСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	215,011,491.00	118,747,894.70

11	ТАТВАРЫН ОРЛОГО	11,248,304.90	14,824,127.10
110	Орлогын албан татвар	9,300,403.40	10,903,708.50
1100	Хувь хүний орлогын албан татвар	9,889,455.00	11,502,511.10
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-589,051.60	-598,802.60
113	Хөрөнгийн албан татвар	1,136,862.00	1,699,316.20
118	Бусад татвар, төлбөр, хураамж	811,039.50	2,221,102.40
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	466,241.60	487,443.40
1181	Газрын төлбөр	151,034.90	188,855.30
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	193,663.10	1,544,803.70
1183	Бусад татвар	100	0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	80,130,952.00	81,647,827.80
120	Нийтлэг татварын бус орлого	8,682,792.80	10,533,067.80
121	Хөрөнгийн орлого	128,808.40	3,678.10
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	71,319,350.70	71,111,081.90
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	123,632,234.20	22,275,939.80
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	182,791,723.80	84,664,100.90
21	УРСГАЛ ЗАРДАЛ	182,791,723.80	84,664,100.90
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	77,509,406.20	79,838,923.40
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	46,944,924.00	48,525,595.70
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,229,833.10	6,617,899.10
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6,753,106.60	7,142,761.50
2104	Хангамж, бараа материалын зардал	1,746,562.20	2,308,542.30
2105	Нормативт зардал	4,118,997.50	2,868,193.90
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	378,896.60	357,115.60
2107	Томилот, зочны зардал	145,726.90	171,539.20
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,328,335.50	2,699,644.10
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,863,023.80	9,147,632.00
211	ХҮҮ	0	0
212	ТАТААС	522,225.40	566,160.70
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	104,760,092.20	4,259,016.90
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	32,219,767.20	34,083,793.80
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	30,633,405.30	29,652,470.80
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	30,633,405.30	29,652,470.80
2200	Дотоод эх үүсвэрээр	30,633,405.30	29,652,470.80
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-30,633,405.30	-29,652,470.80
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-638,457.60	-390,444.90
14	Бусад эх үүсвэр	0	117,001.00
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	638,457.60	504,445.90
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	0	3,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	947,904.30	4,040,878.00

101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	9,794,331.20	10,742,235.50
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	10,742,235.50	14,783,113.50

2.4 АУДИТ ХИЙСЭН НЭГТГЭСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	190,937,015.40	190,937,015.40
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-111,728.10	-111,728.10
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	190,825,287.20	190,825,287.20
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-80,472.80	-80,472.80
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	124,661.80	124,661.80
9	Тайлант үеийн үр дүн	27,392,968.80	27,392,968.80
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	218,262,445.00	218,262,445.00
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	218,262,445.00	218,262,445.00
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	937,937.90	937,937.90
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	219,200,383.00	219,200,383.00
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	208,669.00	208,669.00
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	826,871.50	826,871.50
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	519,581.50	519,581.50
19	Тайлант үеийн үр дүн	26,883,263.90	26,883,263.90
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	247,638,768.80	247,638,768.80

2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	94,740,058.30	88,386,678.13
21	УРСГАЛ ЗАРДАЛ	74,104,519.40	72,331,686.25
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	71,864,636.40	70,133,886.23
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	46,946,603.20	46,585,401.14
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,335,443.90	6,262,887.34
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6,763,244.10	6,632,502.19
2104	Хангамж, бараа материалын зардал	1,189,234.5	1,178,776.72

2105	Нормативт зардал	2,804,234.5	1,906,855.21
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	226,018.4	221,111.6
2107	Томилолт, зочны зардал	180,934.0	158,421.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,661,401.6	1,635,933.38
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,757,522.2	5,551,997.66
212	ТАТААС	566,160.7	566,160.7
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	55,320.0	55,320.0
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	510,840.7	510,840.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,673,722.3	1,631,639.3
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,673,722.3	1,631,639.3
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	18,969,896.7	15,550,545.9
2200	Дотоод эх үүсвэрээр	18,969,896.7	15,550,545.9
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	1,665,642.2	504,445.9
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	94,740,058.3	90,444,076.8
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	48,696,579.5	47,459,597.5
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	38,619,669.4	38,206,595.8
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	505,094.5	446,147.6
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	6,918,714.9	4,331,736.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	2,497,937.35
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	4,555,336.07
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	154	154
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	3,988	3,982
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	26,055	25,637
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	20,206	20,659
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	5,849	4,978
64	ЭМЧЛҮҮЛЭГСДИЙН ТОО	-	84,073
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	3,988	3,982

2.6 АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,836,008.72	9,394,341.67
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,948,694.54	8,983,569.64
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,361,148.01	6,229,666.22
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	120,431.45	487,844.34
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	9,685.37	26,416.12
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	596.00	72,370.87
2104	Хангамж, бараа материалын зардал	58,478.53	201,185.76
2105	Нормативд зардал	117,516.07	966,332.10
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	192,487.35	182,769.86
2107	Томилолт, зочны зардал	29,091.38	10,758.22
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	857,592.57	623,952.21
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,975,269.30	3,658,036.74
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	587,546.53	2,753,903.42
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	582,767.54	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,778.99	1,250,981.89
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	582,767.54	1,502,921.53
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,887,314.19	410,772.03
2200	Дотоод эх үүсвэрээр	1,887,314.19	410,772.03
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	6,836,008.73	9,394,520.73
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,836,008.73	9,394,520.73
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	0.00	179.06
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		179.06

3. АУДИТЫН ТАЙЛАН

3.1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Ховд аймгийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр дансдууд болон төсвийн хэмнэлт, зарцуулалттай холбоотой зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг ахлах аудитор Д.Мөнхтулга, аудитор Д.Эрдэнэцэцэг, Б.Должинжав нар 2022 оны 04 дүгээр сарын 01-нээс 2022 оны 04 дүгээр сарын 20-ны хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Ховд аймгийн Засаг дарга нь 2021 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 1/522 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Ховд аймаг нь “Хүний хөгжлийг дэмжсэн стандарттай шинэ Ховд” гэсэн эрхэм зорилгыг дэвшүүлэн Ковид-19 халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах, биеийн тамир, спортыг эрүүл идэвхтэй амьдралын хэв маяг болгож хүн амд чанартай боловсрол эзэмших боломж бүрдүүлэн тэгш хамруулах, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж хүн амын хөгжлийг хангаж дундаж давхаргын хүрээг өргөжүүлэх, олон тулгуурт ногоон эдийн засагт түшиглэсэн, бүс нутгийн үр ашигтай хамтын ажиллагааг эрхэмлэсэн, үйлдвэрлэл, бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлж, хөрөнгө оруулалтын бодлогыг хэрэгжүүлэхэд төр, хувийн хэвшлийн түншлэлийн зарчимд тулгуурлан, эдийн засгийн өсөлтийг хангах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажилгүйдэл, ядуурлыг орон нутгийн түвшинд бууруулах зорилгыг хэрэгжүүлэн ажилласан байна.

Ховд аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч нь эдийн засгийн тогтвортой хөгжлийн бодлого, нийгмийн хөгжлийн бодлого, байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын бодлого, ил тод, нээлттэй засаглалын бодлогоор ангилан зорилтуудаа тодорхойлон үйл ажиллагааны чиглэл мөрийн хөтөлбөрөө хэрэгжүүлэхээр ажиллажээ..

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

Монгол улсын хууль:

- Хөдөлмөрийн тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Монгол улсын 2021 оны төсвийн тухай
- Эрүүл мэндийн даатгалын тухай хууль
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
- Нийгмийн даатгалын сангийн 2021 оны төсвийн тухай хууль
- “Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль”
- Соёлын тухай хууль
- Эрүүл мэндийн даатгалын сангийн 2021 оны төсвийн тухай хууль

УИХ-ын тогтоол

- "Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах талаар чиглэл өгөх тухай" 2020 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 36 тоот тогтоол
- "Монгол улсын 2020 оны төсвийн гүйцэтгэл баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай" 2021 оны 74 тоот тогтоол
- Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай 2021 оны

Засгийн газрын тогтоол

- 2021 оны 410 дугаар тогтоол "коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлын үед айл өрхөд дэмжлэг үзүүлэх тухай"
- 2021 оны 362 дүгээр тогтоол "Журам батлах тухай"
- 2021 оны 259 дугаар тогтоол "өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай"
- 2021 оны 237 дугаар тогтоол "үдийн хоолны норматив тогтоох тухай"
- 2021 оны 160 дугаар тогтоол "Журам батлах тухай"
- 2021 оны 140 дүгээр тогтоол "Тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулж, журам батлах тухай"
- 2021 оны 124 дүгээр тогтоол "Босго үнэ шинэчлэн батлах тухай"
- 2021 оны 127 дугаар тогтоол "Боловсролын салбарт хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын зарим арга хэмжээний тухай"
- 2021 оны 93 тоот тогтоол "Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлын үед монгол улсын иргэдэд мөнгөн дэмжлэг олгох тухай"
- 2021 оны 43 тоот тогтоол "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай"

Ховд аймгийн ТЕЗ нь санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Аймгийн Засаг даргаас хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Аймгийн Засаг даргаар батлуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу 2021 оны хяналт шалгалтын төлөвлөгөөгөөр хөдөөгийн 8 сумын 66 төсөвт байгууллага, тусгай сангууд, аймгийн төвийн 16 байгууллага, Монгол улсын Сангийн яамны захиалгаар 2 байгууллага, нийт 84 байгууллага, тусгай сангуудын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийхээр төлөвлөж, батлагдсанаас хөдөөгийн 8 сумын 66 байгууллага, тусгай сангууд, Сангийн яамны захиалгаар Гаалийн газар, ГХБХБГ, Татварын хэлтэс, аймгийн төвийн 24 байгууллагад, нийт 93 байгууллага, сангийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийжээ.

Аудитаар 263.5 сая төгрөгийн 202 төлбөрийн акт бичиж албан шаардлага болон зөвлөмжийг өгөөгүй байна. 2019, 2020, 2021 онуудад Санхүүгийн хяналт аудитын алба нь төсөвт байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлэн ажиллахдаа санхүү, нягтлан бодох бүртгэлийг боловсронгуй болгох, санхүүгийн сахилга хариуцлагыг сайжруулах, эрсдэлийг бууруулах талаар ямар нэгэн зөвлөмжийг бүртгээгүй нь Төсвийн тухай хуулийн 69.1¹ дахь заалттай нийцэхгүй байгаад өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдсөн боловч хэрэгжүүлэн ажиллаагүй байна. Мөн аудитын явцад орон нутгийн байгууллагуудын Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хянахад үр нөлөөтэй үнэн зөв хяналтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна. Төрийн байгууллагуудын дотоод аудитын тогтолцоо, чиг үүргийн хэрэгжилтэд хийсэн аудитаар 2 албан шаардлага 15 зөвлөмжийг хүргүүлсэн ч биелэлтийг гаргаж ирүүлээгүй, өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

¹ Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

Ховд аймгийн ТЕЗ нь санхүүгийн үйл ажиллагаандаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нэгдсэн журмаар батлуулж мөрдөөгүй ч батлагдсан хууль, тогтоол журмыг тухай бүр үйл ажиллагаандаа хэрэгжүүлж холбогдох стандарт, журмын дагуу гүйцэтгэж, нэгтгэлд хамрагддаг байгууллагууд бодлогын баримт бичгээ боловсруулан мөрдөж байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Ховд аймгийн ТЕЗ-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2021 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт орлогын 149,430.7 сая төгрөгөөс 1.5 хувиар тооцон 2,241.5 сая төгрөгөөр материаллаг байдлыг тооцон, санхүүгийн тайлангийн түвшинд гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 1,569.0 сая төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга

Ховд аймгийн ТЕЗ-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн өмнөх оноос 31,273.7 сая төгрөгөөр буюу 14 хувиар нэмэгджээ. Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөрийн данснуудад материаллаг өөрчлөлт гарсан байна.

3.5.1 Мөнгөн хөрөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 10,742.2 сая, эцсийн үлдэгдэл 14,783.1 сая төгрөг болж, 4,040.9 сая төгрөгөөр буюу 37.6 хувиар өссөн байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Касст байгаа бэлэн мөнгө	0.4	0.3	-0.1
Банканд байгаа бэлэн мөнгө	10741.8	14782.8	4041
Дүн	10742.2	14783.1	4040.9
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	0	12.1	12.1
Төсөл/ сан	2514.6	4598.8	2084.2

Төрийн сан	8195.4	10054.5	1859.1
ТӨҮГ болон ОНӨҮГ	32.2	117.7	85.5
Дүн	10742.2	14783.1	4040.9

Эх сурвалж: Ховд аймгийн ТЕЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Касст байршиж буй 0.3 сая төгрөг нь ОНӨААТҮГ-ын үлдэгдэл, банканд байршиж буй 14,782.8 сая төгрөгийн 4,598.8 сая төгрөг нь орон нутгийн тусгай зориулалтын сангийн, 117.7 сая төгрөг нь ОНӨААТҮГ-ын, 12.1 сая төгрөг нь төсөвт байгууллагын, 10,054.5 сая төгрөг нь төрийн сангийн дансанд байршиж байна.

Банканд байгаа мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 10,741.8 сая, эцсийн үлдэгдэл 14,782.8 сая төгрөг болж 4,041.0 сая төгрөгөөр буюу 37.6 хувиар өссөн байна.

Хүснэгт №2 Төрийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Банканд байгаа мөнгөн хөрөнгө			
Төгрөг			
Төрийн сан	10710	14665.2	3955.2
Төрийн сангийн нэмэлт данс		0.2	0.2
Арилжааны банк	31.8	117.4	85.6
Нийт дүн	10741.8	14782.8	4041

Эх сурвалж: Ховд аймгийн ТЕЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд орон нутгийн төсвийн орлого 118,747.9 сая төгрөгөөр бүрдүүлж 84,670.9 сая төгрөгийг харьяа байгууллагуудын урсгал санхүүжилтэд, 29,645.7 сая төгрөгийг хөрөнгө оруулалтын санхүүжилтэд, 504.4 сая төгрөгийг СХС-гийн зээлийн санхүүжилтэд зарцуулж оны эцэст 14,783.1 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

ТЕЗ-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар мөнгөн хөрөнгөтэй холбоотой дараах материаллаг дүнтэй алдаа, зөрчил илэрлээ.

- *Сумдын төрийн сангаас мөнгөн хөрөнгийн гүйлгээг санхүүжүүлэхдээ и-баримт дутуу гүйлгээг санхүүжүүлсэн.*
- *Аймаг, сумын ОНХС-гаас иргэдийн санал аваагүй төсөл арга хэмжээг санхүүжүүлсэн.*
- *Дарви сумын сургууль нь анхан шатны баримт дутуу 157.6 сая төгрөгийн ажил гүйлгээг санхүүжүүлсэн.*
- *Аймгийн ЗДТГ нь 255.8 сая төгрөгийг засаг даргын нөөц хөрөнгөөс үр дүнгүй зүйлд зарцуулсан, мөнгөн кассын журмыг зөрчин 218.5 сая төгрөгийг кассаар дамжуулан зарцуулсан.*
- *Хөшөөт хөгжил сангийн хөрөнгөөр 39.3 сая төгрөгийг төрийн байгууллагуудыг тоолууржуулах ажлыг хийсэн ч төсвийн байгууллагуудад тоолуураар тооцоо хийхгүй гэсэн дулааны станцуудаас болж тухайн хөрөнгө нь ашиглагдаагүй, данс бүртгэлд тусгаагүй.*
- *Жаргалант сумын 7-р сургууль ТБОНӨХӨБАҮХАТХ-ийг зөрчин 116.6 сая төгрөгийн нүүрсийг шууд гэрээ байгуулсан.*
- *Булган сум нь Ковид-19 цар тахалтай холбоотойгоор 118.8 сая төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийг зарцуулахдаа анхан шатны баримтын бүрдэл дутуу,*
-

3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 8,825.8 сая төгрөг байснаас эцсийн үлдэгдэл 9,920.7 сая төгрөг болж 1,094.9 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №1 Авлагын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	96.9	92.3	4.6
Төлбөртэй үйлчилгээний авлага	150.9	1,211.2	(1,060.3)
Татаас, санхүүжилтийн авлага	-	7.7	(7.7)
Зээлийн хүүгийн авлага	98.1	112.5	(14.4)
Дансны авлага /ТӨҮГ/	267.5	301.5	(34.0)
Татвар, НДШ-ийн авлага /ТӨҮГ/	0.6	15.5	(14.9)
Байгууллагаас авах авлага	3,040.9	3,972.8	(931.9)
Хүмүүсээс авах авлага	309.1	486.3	(177.2)
Зээлийн авлага	4,861.8	3,720.9	1,140.9
Дүн	8,825.8	9,920.7	(1,094.9)
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	3,711.3	5,898.3	(2,187.0)
Төсөл/ сан	4,861.8	3,720.9	1,140.9
ТӨҮГ болон ОНӨҮГ	252.7	301.5	(48.8)
Дүн	8,825.8	9,920.7	(1,094.9)

Эх сурвалж: ТЕЗ-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд төлбөртэй үйлчилгээний авлага 1,060.3 сая, байгууллагаас авах авлага 931.9 сая, хүмүүсээс авах авлага 177.2 сая, бусад авлага 71.0 сая төгрөгөөр өсөж СХС-ийн зээлийн авлага 1,140.9 сая, ажилчидтай холбогдсон авлага 4.6 сая төгрөгөөр буурчээ.

Нийт авлагад 5 жилээс дээш насжилттай 340.9 сая, 4-5 жилийн насжилттай 281.7 сая, 3-4 жилийн насжилттай 520.1 сая, 2-3 жилийн насжилттай 1593.9 сая, 1-2 жилийн насжилттай 4782.8 сая төгрөгийн авлага байгаа нь авлага эргэн төлөгдөхгүй удааших эрсдэлтэй байна.

СХС-ийн зээлийн авлага 1140.9 сая төгрөгөөр буурч зээлийн үр өгөөж гарч төсвийн орлого нэмэгдсэн байна

Төлбөртэй үйлчилгээний авлага 1060.3 сая төгрөгөөр нэмэгдсэн нь Эрүүл мэндийн төвүүдийн татаас санхүүжилтийн авлага өссөнтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

ТЕЗ-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар авлага данстай холбоотой дараах материаллаг дүнтэй алдаа, зөрчил илэрсэн. Үүнд.

- ЭМТ-үүд нь Эрүүл мэндийн даатгалын сангаас авах санхүүжилтийг дутуу авсантай холбоотойгоор авлагыг нэмээдүүлсэн.*

- Мянган-Угалзат ОНӨААТҮГ-ын 25.2 сая төгрөгийн авлага нь эзэн холбогдогч нь тодорхойгүй найдваргүй авлага байна.
- Дөргөн сумын ТТЗ-ын тайланд эзэн холбогдогч нь тодорхойгүй 34.9 сая төгрөгийн авлага бүртгэлтэй байна.
- Сумдын тайланд насжилт өндөртэй, эзэн холбогдогч нь тодорхой авлагууд оршин байсаар байна. Тухайлбал: Үенч 111.1 сая , АЗДТГазар 213.8 сая, Мөнххайрхан сумын сургууль 0.5 сая,
- СХС-гийн зээлдэгч нарын мэдээллийг Монгол банкны зээлийн мэдээллийн санд оруулсан ч хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл барагдуулаагүй тул ТТЗ-д албан шаардлага хүргүүлсэн.
- Шүүхийн шийдвэрээр ажлаас үндэслэлгүй халагдсан ажилтны цалинд Үенч сум 2 иргэнтэй холбоотой 11.8 сая, Жаргалант сумын 16-р цэцэрлэг 1 иргэнтэй холбоотой 1.5 сая, Ховд сум 1 иргэнтэй холбоотой 1.2 сая төгрөгийг төсвөөс төлж авлагаар бүртгэсэн байна.

3.5.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эхний үлдэгдэл 2,118.5 сая, эцсийн үлдэгдэл 1,743.8 сая төгрөг болж 374.7 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №4 Урьдчилгаа дансны үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалтын сан	597.1	604.8	-7.7
Урьдчилж гарсан зардал	1,399.50	979.4	420.1
Бараа материал бэлтгэх урьдчилгаа	1.7	1.7	-
Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	109.9	151.8	-41.9
Цалингийн урьдчилгаа	10.3	6.1	4.2
Дүн	2,118.50	1,743.80	374.7
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	1,519.60	1,133.10	386.5
Төсөл/ сан	597.1	610.7	-13.6
ТӨҮГ болон ОНӨҮГ	1.8	-	1.8
Дүн	2,118.50	1,743.80	374.7

Эх сурвалж: ТЭЗ-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа зардал 41.9 сая, тусгай зориулалтын сан 7.7 сая төгрөгөөр нэмэгдэж, урьдчилж гарсан зардал 420.1 сая, урьдчилгаа цалин 4.2 сая төгрөгөөр буурсан байна.

3.5.4 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материал оны эхэнд 6,210.4 сая, оны эцэст 7,359.5 сая төгрөг болж 1,149.1 сая төгрөгөөр буюу 18.5 хувиар өссөн байна.

Хүснэгт №5 Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	1077.6	1,473.5	395.9
Хангамжийн материал	4,896.60	5,591.7	695.1
Нөөцийн бараа	236.2	294.3	58.1

Дүн	6,210.40	7,359.5	1,149.1
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	5,517.8	6,607.1	1,089.3
Төсөл/ сан	103.1	83.5	101.6
ТӨҮГ болон ОНӨҮГ	589.5	668.9	170.5
Дүн	6,210.4	7,359.5	1,149.1

Эх сурвалж: Ховд аймгийн ТЭЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд 8,115.2 сая төгрөгөөр худалдан авсан, 27.6 сая төгрөгөөр хандиваар үнэ төлбөргүй, 93.2 сая төгрөгөөр шилжүүлэн авсан, 799.8 сая төгрөгөөр бусад бүгд 9,035.9 сая төгрөгөөр нэмэгдэж, 7,798.0 сая төгрөгийн бараа материалыг байгууллагын үйл ажиллагаанд зарцуулж 44.5 сая төгрөгийг бараа материалын бусад байгууллагуудад шилжүүлсэн, 44.3 сая төгрөгийг бусад нийт 7,886.9 сая төгрөгийн бараа материалыг зарцуулжээ.

Аудитын илрүүлэлт:

ТЭЗ-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар бараа материал данстай холбоотой дараах материаллаг дүнтэй алдаа, зөрчил илэрлээ.

- Ковид-19 цар тахалтай холбоотойгоор 2021 онд захиалсан түргэвчилсэн оношлуур нь хугацаа хоцорч оны сүүлд ирсэнтэй холбоотойгоор сумдын ЭМТ-үүдэд 376.1 сая төгрөгийн оношлуур, эмийн багцын үлдэгдэлтэй байна. Тухайлбал: Манхан ЭМТ 58.7 сая, Мөнххайрхан ЭМТ 52.6, Мөст ЭМТ Цэцэг ЭМТ 33.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.
- Дэргэн сумын ЭМТ нь шинжилгээний бичиггүй 7.8 сая төгрөгийн мах худалдан авсан.
- Ховд сумын ЭМТ нь бараа материалын тайлан гаргаагүй, агуулахын үлдэгдлийн бүртгэл байхгүйтэй холбоотой 575.7 сая төгрөгийн зөрчил илэрсэн.
- Засаг даргын нөөц хөрөнгөөр худалдан авсан бараа материалыг нярвын дансаар дамжуулахгүйгээр шууд зардалд бүртгэх зөрчил илэрлээ. Үүнд: Булган сум 15.9 сая, Жаргалант сум 32.8 сая төгрөгийн бараа материалыг данс бүртгэлд зөрүүтэй тусгасан, шаардах хуудасгүйгээр зардалд бүртгэсэн, Зэрэг сум 15.7 сая төгрөгийг шууд зардалд бүртгэсэн.
- Зарим төсөвт байгууллагууд жилийн эцсээр бараа материалын тооллогыг хийдэггүй зөрчил байсаар байна. Үүнд: Үенч, Дарви, Ховд, Дуут, Чандмань сумдын ЗДТГ-ууд

3.5.5 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 251,806.2 сая төгрөг, оны эцэст 286,786.0 сая болж 34,979.8 сая төгрөгөөр буюу 13.9 хувиар өссөн байна.

Хүснэгт №6 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	237,090.20	272,139.50	35,049.30
Биет бус хөрөнгө	14,716.00	14,646.50	-69.50
Дүн	251,806.20	286,786.00	34,979.80

Үүнээс, байгууллагын төрлөөр

Төсөвт байгууллага	231,716.80	267,748.40	36,031.60
Төсөл/ сан	1,548.40	1,548.40	0.00
ТӨҮГ болон ОНӨҮГ	18,541.00	17,489.20	-1,051.80
Дүн	251,806.20	286,786.00	34,979.80

Эх сурвалж: Ховд аймгийн ТЭЗ-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд 599.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан, 3,392.8 сая төгрөгөөр балансаас балансад шилжүүлэн авсан, 21.4 сая төгрөгөөр үнэ төлбөргүй хандиваар, 34,718.2 сая төгрөгөөр бусад нийт 38,732.3 сая төгрөгөөр нэмэгдэж, 764.2 сая төгрөгөөр балансаас балансад шилжүүлсэн, 2,767.8 сая төгрөгийн хөрөнгийг акталсан, 117.2 сая төгрөгийн хөрөнгийг худалдаж 103.2 сая төгрөгийн хөрөнгийг бусад бүгд 3,752.5 сая төгрөгөөр хасагдсан байна.

Аудитын илрүүлэлт:

ТЭЗ-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар үндсэн хөрөнгө данстай холбоотой дараах материаллаг дүнтэй алдаа, зөрчил илэрлээ.

- Дуут сумын ЗДТГ 54.0 сая төгрөгийн өртөгтэй Ковшийг хувь хүнд ямар нэгэн гэрээгүйгээр эзэмшүүлсэн,
- Аймгийн ЗДТГ, Орон нутгийн өмчийн газрууд үндсэн хөрөнгийн тоолог хийгээгүй
- Үенч сумын сургууль, цэцэрлэг, ЭМТ нь бараа материалын дансанд үндсэн хөрөнгийн шинжтэй хөрөнгийг бүртгэсэн.

3.5.6 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 5,231.3 сая, эцсийн үлдэгдэл 8,461.4 сая төгрөг болж, 3,230.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №7 Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

<u>Үзүүлэлт</u>	<u>Эхний үлдэгдэл</u>	<u>Эцсийн үлдэгдэл</u>	<u>Өссөн+ Буурсан -</u>
<u>Богино хугацаат өр төлбөр дүн</u>	4,287.90	7,518.00	-3,230.10
Ажилчидтай холбогдсон өглөг	73.6	92.2	-18.6
Бараа үйлчилгээний зардлын өглөг	23.9	141.2	-117.3
Хөрөнгө бэлтгэхтэй холбоотой өглөг	17.9	11.5	6.4
Байгууллагад өгөх өглөг	322.6	2,890.20	-2,567.60
<u>Хүмүүст өгөх өглөг</u>	10.5	18.5	-8
<u>Бусад өглөг</u>	299.1	394.5	-95.4
<u>Урьдчилж орсон орлого</u>	3,540.30	3,969.90	-429.6
<u>Урт хугацаат өр төлбөр дүн</u>	943.4	943.4	-
<u>Шим-Ус ОНӨААҮГ</u>	928.4	928.4	-
<u>Чандмань БИТ</u>	15	15	-
<u>Нийт дүн</u>	5,231.30	8,461.40	-3,230.10
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	361.5	244.9	116.6
Төсөл, сан	76.6	2,908.50	-2,831.90
Төрийн сан	3,540.30	3,969.90	-429.6
ТӨҮГ болон ОНӨҮГ	1,252.90	1,338.10	-85.2

ДҮН	5,231.30	8,461.40	-3,230.10
------------	-----------------	-----------------	------------------

Эх сурвалж: ТЭЗ.-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөр 7518.0 сая төгрөг болж өмнөх оноос 3230.1 сая төгрөгөөр өссөн байна. Байгууллагад өгөх өр 2567.6 сая, ажилчидтай холбогдсон өр 18.6 сая, хөрөнгө бэлтгэхтэй холбоотой өр 117.3 сая, урьдчилж орсон барьцаа хөрөнгийн өглөг 429.6 сая, бусад өглөг 109.8 сая төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Нийт өглөгөөс Мянган-Угалзат ОНӨААТҮГ-ын 224.3 сая төгрөг, Шинэ ховд баруун бүсийн төслийн 337.8 сая, Хөшөөт хөгжил сангийн 543.3 сая төгрөг, татаас санхүүжилтийн 1205.1 сая төгрөгийн өглөг нэмэгдсэн нь өглөг өсөхөд гол нөлөө үзүүлсэн байна.

Барьцаа дансанд хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний ажлын гүйцэтгэлийн баталгаа 3969.9 сая төгрөг байршуулж өглөгөө бүртгэсэн тул дараагийн онд барагдах боломжтой өглөг байна.

Урт хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд Шим-Ус ОНӨААТҮГ-ын 928.3 сая төгрөгийн өр нь аймаг, орон нутагт гэр хорооллын ус цэвэрлэх байгууламжийг сэргээн засварлах, газар доорх ус хангамж, ариутгалын систем, дэд бүтцийн тоног төхөөрөмжийг шинэчилж сайжруулах, гэр хорооллын зарим газруудыг төвлөрсөн системд холбож худаг гаргах, Чандмань сумын БИТ төвийг 15.0 сая төгрөгөөр барихад зориулан нийт 943.4 сая төгрөгийн зээл олгогдсон байна.

Аудитын илрүүлэлт:

ТЭЗ-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар үндсэн өр төлбөр данстай холбоотой дараах материаллаг дүнтэй алдаа, зөрчил илэрлээ.

- Мянган-Угалзат ОНӨААТҮГ нь 199.4 сая төгрөгийн өр төлбөр,
- Орон нутгийн өмчийн газар нь батлагдсан орон тооноос илүү хүн ажилласантай холбоотойгоор 7.8 сая төгрөгийн өр төлбөрийг үүсгэсэн.
- Ховд сумын ЭМТ нь тайлант онд нэгдсэн халаалтад холбогдохыг мэдсэн ч 15тн нүүрс бэлтгэж өр төлбөрийг 2.4 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн.
- Өмнөх оны өр төлбөртэй холбоотой өгөгдсөн Чандмань Бит-ын 15.0 сая төгрөгийн ар төлбөрийн зөвлөмж хэрэгжээгүй,

3.5.7 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 218,262.4 сая, эцсийн үлдэгдэл 247,638.8 сая төгрөг болж 19204.3 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №8 Нийт засгийн газрын оруулсан капиталын үлдэгдэл /сая төгрөг/

<u>Үзүүлэлт</u>	<u>Эхний үлдэгдэл</u>	<u>Эцсийн үлдэгдэл</u>	<u>Өсөлт/+, бууралт /-/</u>
Засгийн газрын оруулсан капитал	92,697.5	94,122.0	1,424.5
Хуримтлагдсан үр дүн	71,371.8	99,123.0	27,751.2
Дахин үнэлгээний нэмэгдэл	54,185.1	54,393.8	208.7
Дүн	218,254.4	247,638.8	29,384.4
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	208,024.3	232,126.8	24,102.5
ТӨҮГ болон ОНӨҮГ	<u>10,230.1</u>	<u>15,512.0</u>	5,281.9
Дүн	218,254.4	247,638.8	29,384.4

Эх сурвалж: Ховд аймгийн ТЭЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын оруулсан капитал

Мөст сумын сум дундын эмнэлэг улсын төсвөөс орон нутгийн төсөвт шилжсэнтэй холбоотойгоор 176.8 сая төгрөг, “Шинэ Ховд Жаргалант ТҮК” ОНӨААТҮГ, “Шинэ Ховд баруун бүсийн хөгжлийн корпорац шинээр нээгдсэнтэй холбоотой 523.2 сая төгрөгийн эздийн өмчийг данс бүртгэлд тусгасан байна.

“Шим-Ус” ОНӨААТҮГ нь үнэ төлбөргүй ирсэн 650.5 сая төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгасан, Аймгийн ЗДТГ нь 29.3 сая төгрөг, Манхан сумын сургууль 16.0 сая төгрөгийн газрыг бүртгэсэн, “Мянган-Угалзат” ОНӨААТҮГ 40.0 сая газрыг шилжүүлсэнтэй холбоотойгоор Засгийн газрын оруулсан капитал нийт 1,424.5 сая төгрөгөөр нэмэгджээ.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтөөр 19 байгууллагатай холбоотой үндсэн хөрөнгийн хөрөнгийн дахин үнэлгээ дансыг 208.7 сая төгрөгөөр өссөн байна. Энэ өсөлтөд Мөст сумын эмнэлэг орон нутгийн төсөвт шилжиж ирсэнтэй холбоотойгоор 414.9 сая төгрөгийн дахин үнэлгээний нэмэгдэл өссөнтэй холбоотой байна.

54 байгууллагатай холбоотой 937.9 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдлийн зөрүү болон авлага, өр төлбөрийн зөрүүг өмнөх үеийн үр дүн дансанд залруулсантай холбоотойгоор өмнөх үеийн үр дүн данс буурсан байна.

Тайлант үеийн үр дүн 26,883.3 сая төгрөгөөр хуримтлагдсан үр дүнг өсгөсөн байна.

3.6. ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХҮЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Аудитын багийн хүний нөөц, цаг хугацааны асуудлаас шалтгаалан нэгдсэн удирдамжаар улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалт, орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааны үр ашиг сэдэвт аудитууд хийгдэж байгаа тул дээрх данстуудын хөрөнгийн зарцуулалтыг дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Ховд аймгийн Засаг даргын нэгтгэсэн тайланд тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй дараах асуудлууд байна. Үүнд.

- *Ковид-19 цар тахалтай холбоотойгоор Засгийн газрын 2021 оны 42 тоот тогтоолоор “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-д заасны дагуу Ховд дулааны станц ТӨХК нь 2020-2021 онд 83 аж ахуйн нэгж байгууллагад 685.9 сая, 2000 айл өрхөд 703.9 сая төгрөгийн хөнгөлөлтөд хамруулсан байна. Шим-Ус ОНӨААТҮГ нь 2020-2021 онд 3615 айл өрх, 120 аж ахуйн нэгж байгууллагад 1,099.2 сая төгрөгийн хөнгөлөлтөд хамруулжээ. Аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс 2020 онд 514 ажил олгоогчийн 4,634.8 сая, сайн дурын 5042 даатгуулагчийн 1,836.8 сая нийт 6,471.6 сая төгрөгийг 2021 онд 556 ажил олгоогчийн 1,146.0 сая, сайн дурын 3615 даатгуулагчийн 381.6 сая нийт 1,527.6 сая төгрөгийг нийгмийн даатгалаас чөлөөлжээ. Бадамлах дөл ХХК, Татварын хэлтэс, Ховд цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ууд аудитад шаардлагатай мэдээллийг ирүүлээгүй тул хөнгөлөлтөд хамрагдсан тоон судалгааг аудитад оруулаагүй болно.*
- *Ковид-19 цар тахалтай холбоотойгоор аймгийн төсөвт байгууллагуудад нийт 5.3 сая төгрөгийн мөнгөн хөрөнгө, 6,749.2 сая төгрөгийн бараа материал, 416.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг хандиваар хүлээн авч санхүүгийн тайланд тусгаж хандивын орлогыг цар тахлын үйл ажиллагаанд зарцуулжээ.*
- *ТЕЗ-ын хамрах хүрээний байгууллагуудаас 9-р цэцэрлэг шинэ барилга баригдаж байгаатай холбоотойгоор 33.3 сая төгрөгийн түрээсийн зардалд зарцуулсан байна. Бусад байгууллагууд төрийн өмчит байр ашиглан үйл ажиллагаагаа явуулж байгаа тул түрээсийн зардал төлөөгүй байна.*
- *2021 оны жилийн эцсийн байдлаар аймгийн хэмжээнд Ковид-19 цар тахал туссан 21,143 хүн байгаагаас 12,356 хүн гэрээр эмчлүүлж эмийн багцад 2,035.8 сая, нэг удаагийн хамгаалах хэрэгсэл худалдан авах зардалд 630.1 сая, шатахууны*

зардалд 134.8 сая, цалингийн зардалд 1,980.8 сая, хөрөнгө бэлтгэхтэй холбоотой 121.0 сая, бусад зардалд 221.2 сая төгрөгийг зарцуулжээ.

- Аймгийн Засаг дарга 2021.12.15-нд А/778 тоот захирамжийн 1 дүгээр хавсралтаар боловсролын байгууллагуудад төсвийн зохицуулалтыг 649.7 сая төгрөгөөр, 2021 оны 12.23-нд А/842 тоот захирамжийн 2 дугаар хавсралтаар боловсролын байгууллагуудын төсвийн зохицуулалтыг 16.9 сая төгрөгөөр, 2021.12.23-ны А/842 тоот захирамжийн 2 дугаар хавсралтаар Боловсролын байгууллагуудын төсвийн зохицуулалтыг 275.3 сая төгрөгөөр нийт 941.9 сая төгрөгийн зохицуулалт хийжээ. Үүнээс 13 сургууль ухаалаг самбар авахаар 260.0 сая төгрөгийн урьдчилгаа олгож харьяа байгууллагууд авлагаар бүртгэн 2022 оны 4 дүгээр сард нийлүүлэгдсэн байна.

3.8 Аудитын гол асуудал

Ховд аймгийн Засаг даргын 2021 оны нэгтгэсэн санхүүгийн тайланд үлэмж нөлөө үзүүлсэн дараах асуудлууд байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө данс 4,040.9 сая төгрөгөөр өсөхөд Хоршооны тухай хууль шинэчлэн батлагдаж СХС-г хоршоог дэмжих сан болгосонтой холбоотойгоор сангийн журам 2021 оны 12 сард батлагдаж сангаас гаргаагүйгээс 1,471.0 сая төгрөг болж өмнөх оноос 1,235.6 сая төгрөгөөр өссөн нь нөлөөлжээ.
- Авлага данс 1,094.9 сая төгрөгөөр өсөхөд төлбөртэй үйлчилгээний авлага 1,211.1 сая төгрөг болж өмнөх оноос 1,060.2 сая төгрөгөөр өссөн нь голлох нөлөөг үзүүлжээ. Сумдын ЭМТ-үүд 2021 оны 12 сарын гүйцэтгэлээр санхүүжилтээ Эрүүл мэндийн даатгалын сангаас 2022 оны эхний сард авсантай холбоотой байна.
- Бараа материал данс 1,091.0 өсөхөд Ковид-19 цар тахалтай холбоотойгоор эмнэлгийн хэрэгсэл худалдан авсан, тайлант оны сүүлээр сургуул цэцэрлэгүүд үйл ажиллагаагаа явуулж эхэлсэнтэй холбоотойгоор хүнсний бараа материал нөөцөлсөн нь голлох нөлөөг үзүүлжээ.
- Үндсэн хөрөнгө 25,363.7 сая төгрөгөөр өсөхөд УТХО-аар 2020,2021 онд хэрэгжсэн хөрөнгө оруулалтын ажлуудын гүйцэтгэл голлох нөлөөг үзүүлжээ.
- Өр төлбөр данс 1,897.4 сая төгрөгөөр өсөхөд ЭМТ-үүд нь санхүүжилтээ он гарч авсантай холбоотойгоор эмийн өр үүссэн нь голлох нөлөөг үзүүлжээ.

3.9. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000 нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 153 мэдээллээс 58 мэдээллийг хугацаандаа оруулсан 31, мэдээллийг хугацаа хоцроосон мэдээлгүй буюу цэс хөтлөөгүй 64 мэдээлэл байна. Тендерийн ерөнхий мэдээлэл, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, ОНХС-ын 4-6 сарын гүйцэтгэл, өр авлага үүсгэсэн шийдвэрийн мэдээллийг тус тус мэдээлээгүй байсныг нөхөн мэдээлүүлж залрууллаа.

Аймгийн хэмжээнд сум хөгжүүлэх сангийн Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг мэдээлэх тусгай цэсгүйгээс тайлант онд орсон орлогын гүйлгээ, зээлдэгчийн талаарх мэдээллийг мэдээлээгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР ТОДОРУУЛГА

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид өгсөн 200.0 сая төгрөгийн зөрчлийг арилгах 3 албан шаардлага хүргүүлснээс хариуцлага тооцуулах албан шаардлагыг хэрэгжүүлэн ажиллаж 200.0 сая төгрөгийн авлагыг хуулийн байгууллагад хандан шийдвэрлүүлэх, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангуулан ажиллах албан шаардлагууд хэрэгжээгүй байна.

Нийт 12 зөвлөмж өгснөөс 7 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж, 2 зөвлөмж хэрэгжих шатанд, 3 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй буюу зөвлөмжийн хэрэгжилт 70 хувьтай байна. Хэрэгжилтийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №9 Өмнөх санхүүгийн тайлангаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

д/д	Өгсөн зөвлөмж	Биелэлт	Хувь
1	Аймаг хөгжүүлэх сан, агаарын бохирдлыг бууруулах төсөл хөтөлбөрөөс зээл авсан зээлдэгчдээс үл хөдлөх болон хөдлөх хөрөнгийг барьцаа болгон авч барьцаа хөрөнгийн гэрчилгээг эх хувиар нь авч барьцаалах, зээлийн гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж ажиллах	2021 онд олгосон зээлүүдийн барьцаа хөрөнгийн гэрчилгээг бүрэн авч хэвшсэн. Өмнөх онуудад олгосон зээлдэгч нар зээлийн гэрээг өөрчлөхөөр холбогдох мэдэгдлийг хүргүүлэн ажилласан.	80
2	Булган, Дарви, Зэрэг сумдад дотоод хяналтын баг томилон ажиллуулж, төсвийн хөрөнгө зарцуулалтад хяналт хийх,	2021 онд Санхүүгийн хяналт, аудитын албаны ажлын төлөвлөгөөнд тусгуулан тухайн сумуудад хяналт, шалгалтыг хэрэгжүүлсэн.	100
3	Аймгийн санхүүгийн нэгтгэсэн тайланд тусгагдсан татан буугдсан аж ахуйн нэгж болон эзэн холбогдогч нь тодорхой бус авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, урьдчилгаа, өр төлбөр данстуудад ажлын хэсэг байгуулан ажиллаж хуулийн дагуу шийдвэрлэх	Шүүхийн байгууллагад шилжүүлсэн боловч эзэн холбогдогчийн хаяг тодорхой бус байгаагаас нэхэмжлэлийг хүлээн аваагүй	50
4	СХС-гийн хөрөнгийг эргэцийг сайжруулах, зээлдэгчдийн мэдээллийг холбогдох байгууллагуудтай хамтран Монгол банкны зээлийн мэдээллийн санд бүрэн оруулах ажлыг зохион байгуулах	СХС-ийн зээлдэгчийн мэдээллийг Монгол банкны зээлийн мэдээллийн санд бүрэн оруулж найдваргүй зээлийг 2 дахин бууруулсан.	100
5	ТБОНӨХБАҮХАТХ-ийн холбогдох заалтуудыг баримтлан ажиллаж төсвийн хөрөнгийг үр өгөөжийг нэмэгдүүлэн ажиллах	2021 онд ТБОНӨХБАҮХАТ хуулийг хэрэгжүүлэн ажилласан. Босго үнээс давсан ажилд шууд гэрээ байгуулахдаа Ковид-19 цар тахалтай холбоотойгоор онцгой комиссын дүгнэлтийг гаргуулан ажилласан.	100
6	Төрийн албаны тухай хууль болон Зөрчлийн тухай хуульд заасны дагуу Төрийн албаны зөвлөл болон санхүүгийн хяналт, дотоод аудитаар хяналт хэрэгжүүлэн буруутай албан тушаалтнаар буцаан төлүүлэх арга хэмжээг авч ажиллах	Хэрэгжүүлээгүй	0
7	Цэргийн штабын албан хаагчдын цэргийн цолны цалин болон удаан жилийн нэмэгдлийг Засгийн газрын тогтоолын дагуу олгож хэвших, онцгой нөхцөлийн нэмэгдлийг Төрийн албаны зөвлөлөөр шийдвэрлэн ажиллах	Хэрэгжүүлээгүй	0

8	Цэцэг сумын Хөшөөт багыг нүүлгэн шилжүүлсэнтэй холбоотойгоор хийгдсэн хөрөнгө оруулалтын ажлууд, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангаас бэлтгэгдсэн хөрөнгийг данс бүртгэлд тусгуулах	Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн тогтоолыг гаргуулан ажилласан.	100
9	“Чандмань БИТ”, “Үенч-Эрчим хүч” ОНӨААТҮГ-д нь үйл ажиллагаа явуулахгүй байгаатай холбогдуулан дээрх байгууллагуудын хөрөнгө, авлага, өр төлбөрийн асуудлыг шийдвэрлэн татан буулгах ажлыг зохион байгуулах	Хэрэгжүүлээгүй	0
10	Зэрэг Шим-Ус, Зэрэг Тээлийн-Илч, Минжит булган хот тохижуулах газар, Үенч Мөнх-Ундарга ОНӨААТҮГ-д нь төлөөлөн удирдах зөвлөлгүй, орлогын доод хязгаар, зардлын дээд хязгаар, орон тоог батлуулан ажиллаагүй байгаа тул сумдын ИТХ-аар ТУЗ-ыг батлуулан ажиллах	Тус байгууллагын харьяа сумдын ИТХ-д дээрх асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх зааварчлахыг хүргүүлэн ажиллаж аймгийн хэмжээний бүх ОНӨААТҮГ-дад ТУЗ-ыг 7-9 хүний бүрэлдэхүүнтэйгээр баталж үйл ажиллагааг нь тогтворжуулан ажилласан	100
11	Байгууллагууд хандив цуглуулахтай холбоотой ажлуудыг нэмэлт дансаар дамжуулан зарцуулах эрхийг нээн өгч хандивын орлого, зардлыг санхүүгийн тайланд бүрэн тусгуулан ажиллах	2021 онд Ковид-19 цар тахалтай холбоотойгоор ирсэн хандивуудыг тухайн байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан бүртгэл тайланд бүрэн тусгасан	100
12	Сургууль, цэцэрлэгүүдийн цалингийн сангийн зарцуулалтад хуулийн дагуу төрийн сангийн хяналтыг хэрэгжүүлэн ажиллах	Төрийн сангийн өдөр тутмын хяналтыг хэрэгжүүлэн ажилласан. Цалингийн хэмнэгдсэн зардлыг түлшний хөнгөлөлтөд харилцан адилгүй олгодог байдлыг бүрэн таслан зогсоож төсөвт төвлөрүүлсэн.	100
Нийт дүн			70

3.11 Харьяа байгууллагуудын аудитын дүнгийн талаар

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 165 төсвийн байгууллага, 12 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, 36 тусгай сан, 18 төрийн сан нийт 231 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 206 байгууллага аудитад хамрагдсан, 25 байгууллага аудитад хамрагдаагүй байна. Үүнд: Үенч-Эрчим хүч, Чандмань Бит, Эв эеийн хүч ОНӨААТҮГ-ууд нь үйл ажиллагаа явуулдаггүй тул хамрагдаагүй байна. Бусад байгууллагууд нь Аймаг засаг даргын дэргэд байдаг данснууд тул түүвэрлэн хянасан болно.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудаас 101 байгууллагыг түүвэрт хамруулж, 105 байгууллагад дүгнэлт хүргүүлээ. Үүнд: “Зөрчилгүй”- 79, “Хязгаарлалттай”-25 /Мянгад, Чандмань, Эрдэнэбүрэн сумдын цэцэрлэгүүд, Үенч, Дарви, Чандмань, Цэцэг, Жаргалант сумын 7-р сургуулиуд, Ховд, Дөргөн, Зэрэг, Эрдэнэбүрэн сумды ЭМТ-үүд, Минжит булган спорт цогцолбор, Санхүүгийн хяналт, аудитын алба, Ховд аймгийн ЗДТГ, , Орон нутгийн өмчийн газар, Буянт, Цэцэг, Булган, Дуут, Үенч, Мянгад, Мөст сумдын ТТЗ-ууд, “Мянган-Угалзат” ОНӨААТҮГ, Хөшөөт хөгжил сан/, “Сөрөг” 1 /Мөст сумын ЭМТ/ “санал дүгнэлт өгсөн байна.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 17,724.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 4,781.9 сая төгрөгийн 226 алдааг залруулж, 228.4 сая төгрөгийн зөрчилд 73 төлбөрийн акт тогтоож, 4,083.4 сая төгрөгийн зөрчилд 66 албан шаардлага, 8,610.9 сая төгрөгийн алдаа, зөрчилд 300 зөвлөмж, 19.6 сая төгрөгийн 3 зөрчилд 3 албан тушаалтанд хариуцлага тооцуулах албан шаардлага өглөө.

Хүснэгт 10. Аудитад хамрагдсан харьяа байгууллагын судалгаа алдаа, зөрчил /сая.төгрөг/

/сая төгрөгөөр/													
Д/д	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс									
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлаг а тооцуулах	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ТТЗ	72	3122.4	12	497.3	9	92.9	14	1344.3	35	1168.3	2	19.6
2	ТШЗ	513	11633.5	183	3467.4	58	97.5	32	1110.7	239	6957.9	1	
3	Тусгай сан	61	2316.8	22	648.5	5	27.7	20	1628.3	14	12.3		
4	ОНӨААТҮГ	22	651.4	9	168.7	1	10.3	0	0	12	472.4		
ДҮН		668	17724.1	226	4781.9	73	228.40	66	4,083.3	300	8,610.9	3	19.6

Эх сурвалж: Ховд аймаг дахь ТАГ-ын ТТЗ, ТШЗ, Тусгай сан, ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн аудитын тайлан

3.11.1 Төсвийн төвлөрүүлэн захирагчдын санхүүгийн тайлангийн аудитын дүнгээр илэрсэн алдаа, зөрчил

Төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 17 сумын ТТЗ-ын 17 санхүүгийн нэгтгэсэн санхүүгийн тайлан нэгтгэгдэж аудитад бүрэн хамруулан дүгнэлт гаргаж, 17 тайланг төвлөрүүлэн захирагчдад хүргүүлсэн байна.

Харьяа ТТЗ-ийн 17 сумаас “Зөрчилгүй” 10, “Хязгаарлалттай” 7 /Буянт, Цэцэг, Булган, Дуут, Үенч, Мянгад, Мөст /санал дүгнэлт өгсөн байна.

Аудитаар нийт 3,122.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 497.3 сая төгрөгийн 12 алдааг залруулж, 92.9 сая төгрөгийн зөрчилд 9 төлбөрийн акт тогтоож, 1,344.3 сая төгрөгийн зөрчилд 14 албан шаардлага, 1,168.3 сая төгрөгийн алдаа, зөрчилд 35 зөвлөмж өгч 19.6 сая төгрөгийн 2 хариуцлага тооцуулах албан шаардлага өглөө.

3.11.2 Төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчил

Харьяа төсвийн 141 байгууллагаас 56 санхүүгийн тайланг түүвэрт хамруулж, 85 байгууллагад дүгнэлт гаргаснаас “Зөрчилгүй” 68, “Хязгаарлалттай” 16 /Мянгад, Чандмань, Эрдэнэбүрэн сумдын цэцэрлэгүүд, Үенч, Дарви, Чандмань, Цэцэг, Жаргалант сумын 7-р сургуулиуд, Ховд, Дөргөн, Зэрэг, Эрдэнэбүрэн сумдын ЭМТ-үүд, Минжит булган спорт цогцолбор, Санхүүгийн хяналт, аудитын алба, Ховд аймгийн ЗДТГ, Орон нутгийн өмчийн газар/, “Сөрөг” 1 /Мөст сумын ЭМТ/ дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 11,633.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 3,467.4 сая төгрөгийн 183 алдааг залруулж, 97.5 сая төгрөгийн зөрчилд 58 төлбөрийн акт тогтоож, 1,110.7 сая төгрөгийн зөрчилд 32 албан шаардлага, 6,957.9 сая төгрөгийн алдаа, зөрчилд 239 зөвлөмж, 1 албан тушаалтанд хариуцлага тооцуулах албан шаардлага өглөө.

3.11.3 Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлангийн аудитаар

Харьяа төрийн болон орон нутгийн өмчит 12 аж ахуйн нэгж байгууллагаас 10 байгууллагыг түүвэрт хамруулж 2 байгууллагад дүгнэлт гаргасан байна. “Зөрчилгүй” /Шим Ус ОНӨААТҮГ/ -1, “Хязгаарлалттай” - 1 /”Мянган-Угалзат” ОНӨААТҮГ/ дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 651.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 168.7 сая төгрөгийн 6 алдааг залруулж, 10.3 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 472.4 сая төгрөгийн алдаа, зөрчилд 12 зөвлөмж өглөө.

3.11.4 Орон нутгийн тусгай санд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар

Харьяа 36 тусгай сангаас 35 санхүүгийн тайланг түүвэрт хамруулж, 1 байгууллагад дүгнэлт гаргасан байна. "Хязгаарлалтай" 1 /Хөшөөт хөгжил сан/ дүгнэлт өгч бусад 18 ОНХС, 17 СХС-г түүвэрт хамруулсан.

Аудитаар нийт 2,427.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 648.5 сая төгрөгийн 22 алдааг залруулж, 27.7 сая төгрөгийн зөрчилд 5 төлбөрийн акт тогтоож 1,628.3 сая төгрөгийн 20 албан шаардлага, 123.1 сая төгрөгийн зөрчилд 14 зөвлөмж өглөө.

3. Аудитын илрүүлэлт

Ховд аймгийн ТЕЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 2,589.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 214.5 сая төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт, 1,622.2 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 752.8 сая төгрөгийн алдаа, зөрчилд 8 зөвлөмж өглөө.

4.1 Залруулсан алдаа

Илрүүлэлт: Ховд аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн тайланд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой хугацаа хоцроосон мэдээлгүй буюу цэс хөтлөөгүй 64 мэдээлэл байна. Тендерийн ерөнхий мэдээлэл, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, ОНХС-ын 4-6 сарын гүйцэтгэл, өр авлага үүсгэсэн шийдвэрийн мэдээллийг тус тус мэдээлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Мэдээлээгүй 64 мэдээллийг аудитын хугацаанд нөхөн мэдээлүүлж залруулсан.

4.2 Төлбөрийн акт

4.2.1 Авлагатай холбоотой асуудал

Илрүүлэлт: Энтү ХХК нь агаарын бохирдлыг бууруулах төслөөс барилга барих 200.0 сая төгрөгийн зээл аваад зориулалт бусаар зарцуулсан, гэрээнд заасан 14.5 сая төгрөгийн зээлийн хүүг төлөөгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5-р зүйлийн 5.1.2-д "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх, Төсвийн тухай хуулийн 6-р зүйлийн 6.4.8.төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, 20.1.1-д "Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад баримт бичиг, мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд шаардан гаргуулах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Авлага барагдуулах 214.5 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоох

4.3 Албан шаардлага:

4.3.1 Авлагатай холбоотой асуудал

Илрүүлэлт: Эзэн холбогдогч нь тогтоогдоогүй, зураг төсвийн урьдчилгаа олгоод тооцоо хийгээгүй, зээлийг зориулалт бусаар барьцаагүй олгосон, өмчийн түрээсийн төлбөрийг суутган тооцоогүй зэрэгтэй холбоотой 88 иргэн, аж ахуйн нэгжтэй холбоотой 1,622.2 сая төгрөгийн зөрчил илэрсэн ч өмнөх оны зөвлөмжийн хэрэгжилт хангаагдаагүй зөрчил байсаар байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5-р зүйлийн 5.1.2-д "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх, Төсвийн тухай хуулийн 6-р зүйлийн 6.4.8.төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20

дугаар зүйлийн 20.2.5-д "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Авлага бууруулах жил болгож Засаг даргын захирамжаар ажлын хэсэг байгуулан 1,622.2 сая төгрөгийн авлагыг барагдуулах албан шаардлага өгөх

4.4. Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

4.4.1 Үндсэн хөрөнгө

4.4.1.1 Илрүүлэлт: Аймгийн орох, гарах замд самбар хийх ажлыг 40.0 сая төгрөгөөр, Жаргалант сумын төв 4 замын уулзвараас талын буудлын 3 замын уулзвар хүртэлх 71.0 сая төгрөгийн тохижилтын ажил, Төв халуун уснаас захын зүүн хойд уулзвар хүртэлх тохижилтын ажлыг 19.2 сая төгрөгөөр хийж хүлээн авсан ч данс бүртгэлд тусгаагүй байгаа нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2-т "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлагыг нягтлан бодох бүртгэлд заавал тусгана" гэсэн заалттай нийцээгүй байна.

4.4.1.2 Өгсөн зөвлөмж: Данс бүртгэлд тусгаагүй 130.2 сая төгрөгийн хөрөнгийг 2022 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлангаар данс бүртгэлд тусгах.

4.4.2 Бараа материал

4.4.2.1 Илрүүлэлт: Агаарын бохирдол бууруулах төсөл хөтөлбөрөөс Шинэ Ховд Жаргалант ТҮК-ын ковш 50 механизмд 16.5 сая төгрөгийн бараа материалыг Ээж хайрхан шүтээн ХХК нийлүүлснийг данс бүртгэлд тусгаагүй байгаа нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2-т "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлагыг нягтлан бодох бүртгэлд заавал тусгана" гэсэн заалттай нийцээгүй байна.

4.4.2.2 Өгсөн зөвлөмж: Данс бүртгэлд тусгаагүй 16.5 сая төгрөгийн бараа материалыг 2022 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлангаар данс бүртгэлд тусгах.

4.4.3 Авлагын бүртгэл

4.4.3.1 Илрүүлэлт: Засаг дарга данснаас Үерийн далан сэргээх ажилд Урбан девелопмент консалтинг ХХК-д 95.9 сая, Алтай сумын эвдэрсэн газрыг нөхөн сэргээх ажилд Ариун уул ар булаг ЗГБХН-д 1.8 сая, Буянт сумын гүүр барих ажилд Жаргалант хишиг ХХК-д 44.0 сая, 16 цэцэрлэг хүртэл бетон зам тавих ажилд Кеналхап ХХК-д 29.5 сая, Лагерт бие засах газар байгуулах ажилд Хойлог хайрхан ХХК-д 11.2 сая төгрөгийн санхүүжилтийг олгож тухайн ажлууд нь хийгдэж дуусаагүй байхад авлагаар бүртгээгүй байгаа нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2-т "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлагыг нягтлан бодох бүртгэлд заавал тусгана" гэсэн заалттай нийцээгүй байна.

4.4.3.2 Өгсөн зөвлөмж: Хөрөнгө оруулалтын ажлуудыг 2022 онд бүрэн хэрэгжүүлэн ажиллаж хийгдсэн ажлуудыг холбогдох байгууллагуудын данс бүртгэлд тусгах.

4.4.4 Өглөгийн бүртгэл

4.4.4.1 Илрүүлэлт: Шинэ Ховд баруун бүсийн хөгжлийн корпорац нь тайлант онд 225.3 сая төгрөгийн 2ш хадлангийн иж бүрдлийг зээлээр авч данс бүртгэлд тусгасан ч өр төлбөрийг хэрхэн барагдуулах нь тодорхой бус байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалттай нийцээгүй байна.

4.4.4.2 Өгсөн зөвлөмж: Зээлээр ирсэн хөрөнгийг цаашид ашиглалтын гэрээ байгуулан хөрөнгийн ашиглалтыг сайжруулан төсөвт өр төлбөрийг барагдуулах төсвийг батлуулах.

4.4.5 Хоршоо хөгжүүлэх сангийн хөрөнгийн ашиглалт

4.4.5.1 Илрүүлэлт: СХС-ын журам өөрчлөгдөж Хоршоог хөгжүүлэх сан болсонтой холбоотойгоор сумдын СХС-д оны эцэст 1,471.0 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй, СХС-аас тайлант онд 504.4 сая төгрөгийн зээлийг олгож хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл 1,660.9 сая төгрөг болж өмнөх оноос 1,524.7 сая төгрөгөөс буурсан ч 7 сараас эхлэн зээл олгоогүй байна. Хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл 1,660.9 сая төгрөг байна.

4.4.5.2 Өгсөн зөвлөмж Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/361 тоот тушаалын дагуу хоршоог хөгжүүлэх сангийн хөрөнгийн эргэцийг сайжруулах.

4.4.6 Засгийн газрын 43 тоот тогтоолын хэрэгжилттэй холбоотой асуудал

4.4.6.1 Илрүүлэлт: Засгийн газрын 2020 оны 144 болон 2021 оны 43 тоот тогтоолыг хэрэгжүүлээгүйгээс тогтмол зардлыг 130.7 сая төгрөгөөр буюу 2 хувиар хэмнэж тогтоол заасан хэрэгжилтийг хангаагүй байгаа нь ЗГ-ын 2020 оны 04 дүгээр сарын 24-ны өдрийн 144 тоот тогтоолын 1-д "Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, бусад төсөвт байгууллагын дулааны эрчим хүчний хэрэглээг хэмжүүрээр тооцох нөхцөлийг бүрдүүлж, тоолууржуулах ажлыг 2020 оны III улиралд багтаан зохион байгуулж, хэрэгжүүлэхийг Төсвийн захирагч, гүйцэтгэх удирдлага нарт үүрэг болгосугай" ЗГ-ын 2021 оны 43 тоот тогтоолын 1.8-д "байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд 20-иос доошгүй хувийн хэмнэлт гаргах" гэсэн заалттай нийцээгүй байна.

4.4.6.2 Өгсөн зөвлөмж ЗГ-ын 2020 оны 144 тоот тогтоолыг хэрэгжүүлэн ажиллаж аймаг, сумын хэмжээнд нэгдсэн халаалтын үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдтэй байгуулсан гэрээнд өөрчлөлт оруулан тоолууржуулах ажлыг эрчимжүүлэн Хөшөөт хөгжил сангийн хөрөнгөөр бэлтгэсэн дулааны тоолуурыг холбогдох төсвийн байгууллагуудад нь хүлээлгэн өгч данс бүртгэлд тусгуулах

4.4.7 Засгийн газрын 43 тоот тогтоолын хэрэгжилттэй холбоотой асуудал

4.4.7.1 Илрүүлэлт: Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс бэлэг дурсгалыг зүйл авахад 9.6 сая, арга хэмжээний зардалд зочид буудлуудад 54.3 сая төгрөгийг зарцуулсан нь ЗГ-ын 2021 оны 43 тоот тогтоолын 1.6-д "Засгийн газрын шийдвэр гарснаас бусад баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын уралдаан тэмцээн, салбарын өдөр, аялал зугаалга зэргийг зохион байгуулахгүй байх" гэсэн заалттай нийцээгүй

4.4.7.2 Өгсөн зөвлөмж Засаг даргын нөөц хөрөнгийг төсвийн тухай хууль болон холбогдох журмын дагуу хэмнэлттэй, үр ашигтай байхаар зарцуулах

4.4.8 Худалдан авалттай холбоотой асуудал

Тайлант онд агаарын бохирдлыг бууруулах төсөл хөтөлбөрөөс Зол дайчин ХХК 135.0 сая төгрөгийн 2ш тээврийн хэрэгсэл, Бат дайчин ХХК 230.0 сая төгрөгөөр 3ш тээврийн хэрэгсэл, Ээж хайрхны шүтээн ХХК 6.0 сая төгрөгөөр гар аргаар цас цэвэрлэх тоног төхөөрөмж нийлүүлэхээр шууд гэрээ байгуулан ажилласан боловч ажлын тоо хэмжээнээс зөрүүтэй, баталгаат хугацаанд нь эвдрэлийг засаж өгөөгүй, шууд гэрээ байгуулсан аж ахуйн нэгжүүд нь өмнө нь тээврийн хэрэгсэл нийлүүлж байсан туршлагагүй байхад үнийн санал авах урилга явуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.2-д "сүүлийн 5 хүртэлх жилийн хугацаанд гүйцэтгэсэн ажлын жагсаалт, тэдгээрээс гүйцэтгэсэн ижил төстэй ажлын өртөг, хугацаа, байршил, бүрэн гүйцэтгэсэн болохыг тодорхойлсон өмнөх үйлчлүүлэгчийн тодорхойлолт" 16.1.3-д "сүүлийн 5 хүртэлх жилийн хугацаанд нийлүүлсэн бараа, үйлчилгээ, тэдгээрийн үнийн дүн, хугацаа болон худалдан авагчдын жагсаалт, шаардлагатай бол бараа, үйлчилгээний гүйцэтгэлийн талаарх өмнөх худалдан авагчдын тодорхойлолт", 34.2-д "Энэ хуулийн 34.1-д заасан нөхцөлийн дагуу шууд гэрээ байгуулахад захиалагч энэ хуулийн 14-16 дугаар зүйлийн шаардлагыг хангасан, тухайн

бараа, ажил, үйлчилгээг гүйцэтгэх чадавхтай нэг, эсхүл түүнээс дээш тооны этгээдтэй хэлэлцээ хийж, техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл, шаардлагыг хамгийн сайн хангасан этгээдтэй энэ хуульд заасны дагуу гэрээ байгуулах бөгөөд хэлэлцээний үед хүрсэн аливаа тохиролцоог гэрээнд тусгана” 34.3-д “Энэ хуулийн 34.1-д заасны дагуу гэрээ шууд байгуулсан тохиолдолд захиалагч гэрээний хувийг уг аргыг хэрэглэх болсон үндэслэлийн хамт төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шууд гэрээ байгуулсан 371.0 сая төгрөгийн гэрээний хэрэгжилтэд дотоод хяналт хэрэгжүүлэн зөрчлийг арилгуулах

4. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ

Д/д	Байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс / сая,төгрөгөөр/							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Аймгийн засаг дарга	11	2589.5	1	0	1	214.5	1	1622.2	8	752.8
	Дүн	11	2589.5	1	0	1	214.5	1	1622.2	8	381.8

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Шалгагдагч байгууллагаас ирүүлсэн тайлбар, санал :



**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Х.БОЛДБААТАР ТАНАА**

Аймгийн 2021 оны төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд хийсэн аудитын дүгнэлттэй танилцлаа.

Аудитын дүгнэлтэд дурдсан алдаа, албан шаардлага, зөвлөмжийг зөвшөөрч байгаа ба цаашид холбогдох байгууллагуудтай хамтарч хэрэгжилтийг ханган дүнг тогтоосон хугацаанд тайлагнах болно.

Б.ДҮГЭРЖАВ

8200 04 1071
2022 A/5 Kh

